

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	2
Төслийн товч танилцуулга	2
1.2. Уурхайн хүчин чадал	5
2. 2025 ОНД ХИЙСЭН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖИЛ.....	8
3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	8
3.1. Агаар орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажил.....	8
3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажил...	10
3.3. Хөрс, ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад хийгдсэн ажлууд.....	11
3.4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	14
3.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	3.6.
Түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс	19
3.7. Химийн бодис эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	19
3.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	19
ДҮГНЭЛТ	23

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ


Төслийн товч танилцуулга

MV-008469 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь Айраг сумын нутаг дэвсгэр L-49-75 хавтгай дээр, Хайртын уурхайн зүүн талд, Улаанбаатар хотоос зүүн урагш, төмөр замаас 310 км зайд, Айраг төмөр замын өртөөнөөс 8.5 км зайд оршино.

Өмнөт Хар-айраг хайлуур жоншны ордын талбай нь 76.08 гектар талбайг хамардаг. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбицлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. MV-008469 тоот талбайн солбицол

Тусгай зөвшөөрлийн дугаар, талбайн хэмжээ	Эргэлтийн цэгүүд	Газарзүйн солбицол (WGS84)		Тэгш өнцгийн солбицол (WGS84-UTM49N)	
		Уртраг, У	Өргөрөг, Х	Х (м)	Ү (м)
MV-008469 76.08 гектар	1-2	109° 22' 32.73"	45° 46' 17.62"	5069949.685	373715.074
	2-3	109° 22' 32.73"	45° 46' 00.62"	5069425.040	373704.414
	3-4	109° 24' 26.73"	45° 46' 00.62"	5069375.502	376166.691
	4-5	109° 24' 26.73"	45° 46' 03.62"	5069468.086	376168.536
	5-6	109° 24' 01.73"	45° 46' 03.62"	5069478.866	375628.571
	6-7	109° 24' 01.73"	45° 46' 11.61"	5069725.449	375633.504
	7-1	109° 23' 01.73"	45° 46' 11.61"	5069751.513	374337.640



Зураг 1. Төслийн талбайн байршлын тойм зураг

Физик газарзүйн нөхцөл. MV-008469 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь физик газарзүйн хувьд намхан уул толгодорхог рельеф бүхий далайн түвшнээс дээш дунджаар 1200 м-т өргөгдсөн говь, тал хээрийн бүслэлд багтана. Монгол орны физик газарзүйн мужлалаар говийн их мужийн умард говийн ухаа толгодот тал гэсэн тойрогт багтана. Байгалийн бүсийн хувьд цөлжүү хээрийн бүсэд оршдог. Энэ тойрогт ухаа гүвээт тал зонхилох боловч тойргийн өмнөд хэсгээр 900-1900 м-ийн үнэмлэхүй өндөр бүхий Дэлгэрхангай, Их Шанхайн уул нурууд оршдог.

Уур амьсгал. Төсөл хэрэгжих нутаг нь дулаан зунтай чийг дутмаг мужид багтана. Бүх нутгаар агаарын хэм харьцангуй жигд тархалттай байдаг. Ургамалшил тачирхан, чулуурхаг буюу элсэрхэг гадаргатай тул наранд халж агаарын хэмийг нэлээд дээшлүүлдэг.

Агаар, хөрсний температур. Дорноговь аймгийн зүүн хэсгээр жилийн дундаж агаарын температур 5.50С, нутгийн хойд хэсгээр харьцангуй хүйтэн 0.3⁰С, бусад нутгаар 3.5-3.7⁰С дулаан байна. Жилийн хамгийн дулаан 7-р сарын дундаж агаарын температур нутгийн хойд талаар 18.7⁰С, зүүн хэсгээр 21.3⁰С, төв болон өмнөд хэсгээр 23.1-24.0⁰С дулаан байна. Дулааны улиралд 20-25⁰С хэм халах боловч 30⁰С ба түүнээс дээш хэм халах явдал жилд дунджаар 30-39 хоног тохиолдоно. Жилийн хамгийн хүйтэн 1-р сарын агаарын дундаж температур тус аймагт -15.3⁰С (Хөвсгөл станц)....-20.7⁰С (Чойр станц)-ын хооронд хэлбэлзэнэ. Сарын дундаж агаарын температурын дундаж квадрат хазайлт өвлийн саруудад 2.0-3.4⁰С, зуны саруудад 1.3-1.5⁰С тус тус байна. 11-р сараас 12-р сар хүртэл хөрсний дундаж температур -3.6⁰С-аас-13.2⁰С хүртэл буурдаг ба 3-р сараас 10-р сар хүртэлх хугацаанд 0.3⁰С-аас 29⁰С хүрдэг. Жилийн дундаж хөрсний гадаргын температур нутгийн хойд талаар 2.4⁰С, Хөвсгөл станц орчмоор хамгийн дулаан 7.5⁰С бусад нутгаар 5.0...6.0⁰С дулаан байна. Улирлын хөлдөлтийн явцын дундаж гүн шаварлаг хөрсөнд 1.5 метр, элсэрхэг хөрсөнд 1.9 метр, хайргархаг хөрсөнд 2.2 метр хүрдэг байна. Хөлдөлтийн гүн нь хөрсний төрөл, чийгийн агууламжаас хамааран янз бүр байх боловч ерөнхийдөө 2 метрээс хэтэрдэггүй.

Нарны цацраг. Төсөл хэрэгжих нутагт жилдээ дунджаар 3338 цаг нар гийгүүлнэ. Нар гийгүүлэх хугацаа өвөлдөө бага 256 цаг, зундаа их 309 цаг байна. Жилийн дундаж нийлбэр цацраг тус нутгаар 434.5 Мдж/м² байна.

Агаарын чийгшил, хур тунадас. Төсөл хэрэгжих нутгийн хойд талаар жилдээ 193.8мм, зүүн өмнөд хэсгээр 128.7мм, бусад нутгаар 100.9-113.5мм хур тунадас унана. Хур тунадасны хэмжээ маш ядмаг юм. Энэ нь хойт мөсөн далайн болон Номхон далайн агаар нэвтрэн ирэх боломж муу байдаг, гол төлөв эх газрын эрс тэс уур амьсгалтай байдалтай холбоотой юм. Төсөл хэрэгжих нутгаар жилийн дундаж харьцангуй чийгшил нутгийн хойд хэсгээр 65%, бусад нутгаар 53-59 % байна. Жилийн дундаж дутагдал чийг нутгийн хойд хэсгээр 4.7 гПа, өмнөд болон зүүн хэсгээр 5.8-6.6 гПа, бусад газраар 7.1-7.7 гПа байна. Жилийн дундаж усны уурын даралт 5.4-5.9 гПа байна.

Агаарын даралт, салхи. Дорноговь аймаг ерөнхийдөө тэгш талархаг нутагтай учир станцын түвшин дэх агаарын даралтын зөрөө багатай. Жилийн дундаж агаарын даралт 865.7-905.0гПа-ын хооронд хэлбэлзэнэ. Салхины жилийн дундаж хурд нутгийн зүүн өмнөд хэсэгт харьцангуй бага 2.9м/с, бусад хэсгээр 3.1-4.3м/с байна. Баруун болон баруун хойд чиглэлийн салхи зонхилдог. Баруун чиглэлийн салхины давтагдал нийт нутгаар 12.1-47.7%, салхины дундаж хурд нь 5.2-6.9м/с, хойд чиглэлийн давтагдал 11.3-40.6%, салхины дундаж хурд 4.4-6.3м/с тус тус байна. Замын-Үүдэд зүүнээс 11.7%-ийн давтагдалтай салхины гурав

дахь зонхилох чиглэл ажиглагддаг нь орон нутгийн онцлогийг тод харуулж байна. Дорноговь нийт нутгаар манай орны бусад нутгаас жилийн туршид салхи ихтэй өвөлдөө ч төдийлөн салхины хурд буурдаггүй онцлогтой. Хамгийн хүчтэй салхи шуурга 3-р сарын сүүлчээс 4-р сард ихэвчлэн хойд болон баруун хойноос чиглэлтэйгээр салхилдаг.

Цаг агаарын үзэгдэл. Дорноговь аймгийн нутагт жилдээ 28.6-43.8 өдөр бороо, 14.2-23.2 өдөр цас, 0.1-1.0 өдөр мөндөр ордог. Дуу цахилгаан жилдээ 4.1-45.3 өдөр, цасан шуургатай өдөр жилдээ 4.7-11.8 өдөр, шороон шуургатай өдөр 16.4-68.2 өдөр тус тус ажиглагддаг байна. Шороон шуурга нь тус бүс нутгийн агаарын чанарт мэдэгдэхүйц нөлөөлөл үзүүлнэ. 4-р сард салхины дундаж хурд 5.5 м/сек байдаг. Хааяа салхи шуурга богино хугацаанд 40 м/сек хүрч шуурна.

Агаарын чанар. Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт цаг уурын ажиглалтын нийт 5 станц, 8 харуул хэвийн ажиллаж байна. Агаарын чанарыг хянах зорилгоор цаг уурын станцуудад суурин болон зөөврийн багажаар агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулагч бодис болох нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), азотын давхар исэл (NO₂), хүхэрлэг хий (SO₂), PM2.5 тоосонцор, PM10 тоосонцор, TSP нийт тоосны агууламжийг тодорхой хугацаанд хэмжин “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016 стандартын хүлцэх агууламжтай харьцуулан, үр дүнг гаргаж мэдээллийн сан үүсгэж байна. Дорноговь аймгийн Сайншанд сумын агаарын чанарын харуулын агаарт агуулагдах *хүхэрлэг хий (SO₂)*, *азотын давхар исэл (NO₂)*-ийн агууламжийг 7 хоногт 2 удаагийн давталттайгаар хэмждэг бөгөөд Сайншанд сумын агаарын чанарын 7 хоногийн мэдээ /2020.08.17-2020.08.24/-ний хэмжилтийн үр дүнгээр “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016 стандартын хүлцэх агууламжаас даваагүй, агаарын чанарын индекс *Цэвэр*, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байна.

Физик бохирдол. Төслийн явцад цацраг идэвхжилийн бохирдол, дуу чимээ үүснэ. *Физик бохирдлын эх үүсвэрт* тэсэлгээ, хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмж гэх мэт орно. Төслийн явцад богино хугацаанд шууд бус замаар дуу шуугианы бохирдол үүснэ. Ялангуяа уурхайн тоног төхөөрөмж, тэсэлгээний ажил, хүнд даацын машин механизмын эх үүсвэрээс үүдэлтэй механик шуугиан үүснэ. Тэслэлт хийхэд үүсч байгаа хэт их даралтын хүч нь тэрхүү энерги тэсэлгээний талбайгаас агаар мандлаар тархахдаа даралтын долгион хэлбэртэй тархдаг. Тэсрэлтийн үед даралтын долгионы хүч асар хурдтай нэмэгдэж, тархахдаа тэрхүү хүч нь маш аажмаар суларна. Тэгсээр олон удаа хэлбэлзсэний дараа анхны байдалдаа ортлоо буурна. Даралтын долгион нь хүний чихэнд сонсогдохуйц (дуу чимээ) ба хүний чихэнд үл сонсогдох (тархи доргих) гэсэн хоёр энергийн хүчээс бүрдэнэ.



Нийгэм, эдийн засаг. Төсөл хэрэгжих Айраг сум нь нийт 4 багтай бөгөөд MV-008469 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Өмнөд Хар-Айрагийн хайлуур жоншны орд нь засаг захиргааны хувьд Сайн-Ус багийн нутагт хамаарагдана. Айраг сум нь Дорноговь аймгийн төв Сайншанд сумаас баруун хойш 124 км, Улаанбаатар хотоос зүүн урагш 330 км-т төмөр замын дагуу байрладаг. Айраг сумын төв нь төсвийн 7 байгууллага, төрийн өмчит 3 нэгж, тусгай зөвшөөрөлтэй аж ахуй 7, патентаар үйл ажиллагаа явуулдаг 47 байгууллага байна. Тус суманд 320 хүүхдийн суудалтай ЕБСургууль, 50 ортой дотуур байр, 15 ортой хүн эмнэлэг, 75 ортой хүүхдийн цэцэрлэг, 100 суудалтай соёлын төв үйл ажиллагаа явуулдаг. Дэд бүтцийн хувьд төвийн эрчим хүчинд холбогдсон, үүрэн телефоны үйлчилгээ нэвтэрсэн. Нийслэл Улаанбаатар хот болон Дорноговь аймгийн төвтэй төмөр зам, авто замаар холбогдсон томоохон сум юм.

Айраг сумын онцлог. Айраг сумын төв нь Монгол Оросын хувь нийлүүлсэн Төмөр замын зангилаа байрлаж, үйл ажиллагаа явуулж байгаагийн зэрэгцээ, Онцгой байдлын ерөнхий газрын харъяа шатахууны нөөцийн салбар, Аврах гал унтраах 23 дугаар анги, 110/35/10 кВт-ын цахилгаан дамжуулах дэд станц зэрэг томоохон аж ахуйн нэгж байгууллагууд байрлаж үйл ажиллагаагаа явуулдаг. Хүн ам олноор төвлөрсөн харьцангуй хотожсон сум юм. Энэ нөхцөл нь хүн амын шилжилт хөдөлгөөний тогтвортой байдалд эерэгээр нөлөөлж байна. Хүн амын механик өсөлтөөс шалтгаалан Айраг сумын төвийн суурьшлын бүс тэлэн хөгжиж байна.

2019 оны жилийн эцсийн статистикийн мэдээгээр Айраг сумын суурин хүн амын тоо 3714, насны ангиллаар авч үзвэл 0-14 насны хүүхэд 1128, хөдөлмөрийн насны иргэн 2334, тэтгэврийн насны 60-аас дээш насны иргэн 252 байжээ. Хөдөлмөр эрхлэлтийн хувьд бүртгэлтэй ажилгүй иргэн 20, нийт ажилгүй иргэдийн 80 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгааг боловсролын түвшингээр нь авч үзвэл 13 хувийг дээд, 4 хувийг тусгай дунд, 61 хувийг бүрэн дунд, 16 хувийг бүрэн бус дунд, 6 хувийг бага буюу боловсролгүй хүмүүс тус тус эзэлнэ. Айраг сумын хэмжээнд нийт 57 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж 20.7 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж улсад 363.5 сая.төг, аймагт 163.4 сая.төг, орон нутагт 93.1 сая.төг, нийт 620.0 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 733. сая.төг байгааг өнгөрсөн мөн үетэй харьцуулахад 122.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн даатгалын сангийн зарлага мөн 110.9 сая.төгөөр нэмэгджээ. Хөдөө аж ахуйн хувьд Айраг сумын хэмжээнд малчдын тоо 545 байгаагаас дийлэнх хувийг 35-59 насны иргэд эзэлж байна. Малтай болон малчин өрхийн нийгмийн ахуйн үзүүлэлтүүд жилээс жилд өсөх хандлагатай байна. Тухайлбал, цахилгаантай малчин өрх нийт малчдын 84.5%, телевизортой 77.2%, автомашинтай 62.1%, мотоциклтой 70.9%, гар утастай малчин өрх 100% байна. Энэ нь малчин өрхийн нийгмийн үзүүлэлтүүд жилээс жилд сайжирч, нийгмийн хөгжлийн дагуу хувьсан өөрчлөгдөж буйг харуулж байна.

1.2. Уурхайн жилийн хүчин чадал

Далд уурхайн жилийн хүчин чадлын хэмжээг тодорхойлохдоо судал хэлбэрийн тогтоцтой, босоо уналтай хүдрийн биетийг олборлох нөхцөлд далд уурхайн жилийн хүчин чадлыг олборлолтын ажлын жилийн дундаж гүнзгийрэлтээс хамаарсан томьёогоор тодорхойлов.

2-р хүснэгт. Уурхайн хүчин чадал

№	Үзүүлэлт	Тэмдэглэгээ	Хэмжих нэгж	Тоон утга
1	Олборлолтын ажлын жилийн дундаж гүнзгийрэлт	V	м	25
2	Хүдрийн биетийн урт	L	м	200
3	Хүдрийн биетийн дундаж зузаан	m	м	2.0
4	Хүдрийн эзлэхүүн жин	Y	тн/м ³	2.60
5	Хүдрийн биетийн зузааныг тооцсон итгэлцүүр	K ₁	-	1.2
6	Хүдрийн биетийн уналын өнцгийг тооцсон итгэлцүүр	K ₂	-	1.1
7	Хүдэр авалтын итгэлцүүр	K _a	-	0.9
8	Бохирдолт тооцсон итгэлцүүр	p		0.95
9	Жилийн хүчин чадал	Q	мян.тн	32.0

Ашиглах хугацаа

Уулын ажлын үргэлжлэх оновчтой хугацаа буюу ашиглалтын хугацааг ашигт малтмалын зах зээлийн эрэлт хэрэгцээ (тухайлбал, бүтээгдэхүүний тухайн үеийн зах зээлийн үнэ), тоног төхөөрөмжийн бүтээл, уурхайн жилийн хүчин чадал зэргээс хамааруулан тодорхойлно. Далд уурхайн жилийн хүчин чадлаас хамааруулан ашиглалтын хугацааг тодорхойлбол:

$$T = \frac{Q_a}{A_{\text{ж}}} = \frac{87399.2}{32000} = 2.73 \approx 3 \text{ жил}$$

Энд: Q_a – Ашиглалтын нөөц /тн/

A_ж – Далд уурхайн жилийн хүчин чадал /тн/

Тус уурхайг ашиглах ашиглалтын эхний жилд үндсэн ба бэлтгэл малталт нэвтрэлт, бэлтгэл ажил, сүүлийн жилд уурхайг хаах, нөхөн сэргээх, суурин болон зөөврийн техник,

тоног төхөөрөмжүүдийг хураах, барилга байгууламжуудыг буулгах зэрэг ажлууд шат дараалалтайгаар хийгдэх тул нийт ажиллах хугацааг 3 жил байхаар тооцсон.

Уулын ажлын горим

Далд уурхайн ажиллах горим: Далд уурхайн ажиллах горимыг захиалагч байгууллагаас төсөл боловсруулах даалгаварт тусгагдсаны дагуу дараах байдлаар төлөвлөсөн. Энд:

3-р хүснэгт. Далд уурхайн ажиллах горим

№	Үндсэн хэмжигдэхүүнүүд	Хэмжих нэгж	Тоон утга
1	Жилийн хуанлийн хоног	хоног	365
2	Баяр ёслолын үеийн амралтын хоног	хоног	15
3	Сул зогсолт	хоног	80
4	Уурхайн ажиллах хоног	хоног	270
5	Хоногт ажиллах ээлжийн тоо	-	2
6	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12

Уурхайн календарь төлөвлөгөө

4-р хүснэгт. Уурхайн календарь төлөвлөгөө

№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	Ашиглалтын жил			
				Нийт	1	2	3
Үндсэн малталт							
1	Хүдрийн биет - I	Агааржуулалтын босоо гол ам №1	м	10	10		
2		Налуу гол ам №1	м	160	60	100	
3		Квершлаг	м	20	20		
4		Штрек	м	240		240	
5		Орт	м	200		100	100
6		Восстающий	м	240		90	150
7	Хүдрийн биет - II	Налуу гол ам №2	м	240	240		
8	Нийт үндсэн малталт нэвтрэлт		м	430	330	100	
9	Нийт бэлтгэл малталт нэвтрэлт		м	680		430	250
10	Нийт малталт нэвтрэлт		м	1110	330	530	250
11	Малталт нэвтрэлтээс гарах хоосон чулуулгийн хэмжээ		м ³	6.55	2.50	3.30	0.75
Хүдэр олборлолт							
1	Хүдрийн биет - I	B'-5	мян.тн	17.89		17.89	
2		B'-6	мян.тн	14.70		7.37	7.33
3		B'-7	мян.тн	9.02			9.02
4		B'-8	мян.тн	8.17			8.17
5		B'-9	мян.тн	7.48			7.48
6	Хүдрийн биет - II	B'-1	мян.тн	7.89	7.89		
7		B'-2	мян.тн	7.88	7.88		
8		B'-3	мян.тн	5.40	5.40		
9		B'-4	мян.тн	8.97	2.23	6.74	
10		Овоолго	мян.тн	0.45	0.45		
11	Нийт	Хүдэр	мян.тн	87.85	23.85	32.0	32.0
12		Агуулга	%	52.18	58.62	50.67	48.89
13		Эрдэс	мян.тн	45.84	13.98	16.22	15.64

2. 2025 ОНД ХИЙСЭН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖИЛ

2025 оны Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт, биелэлт

“Техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэхдээ техникийн нөхөн сэргээлтийн ажлын үр дүнд тавих үндсэн шаардлага, байгалийн үндсэн бүсээс хамаарах агротехникийн шаардлага, ургамлын нөхөн сэргээлтийн үе шатууд, тарих ургамлуудыг сонгох болон нөхөн сэргээсэн газрыг хүн, мал, салхи, усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах, нөхөн сэргээж буй газрын хөрс, ургамлын хяналт шинжилгээнд тавих шаардлагын дагуу хийж гүйцэтгэх зорилго тавин ажилласан болно.

Тус орд нь далд аргаар үйл ажиллагаа явуулж байгаа учраас 2025 онд биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй. Уурхайн талбайд хайлас, бургас, улиас хийлээд 550ш тарьсан.

Дүйцүүлэн хамгаалах ажлаар орон нутгаас зааж өгсөн талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1. Агаар орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажил

Үйл ажиллагаа явагдахаас өөр газруудад машин, техникүүдийг замбараагүй явуулахгүй байх зааварчилгааг тогтмол өгч мөрдүүлж ажилласан.

Хүснэгт 5. Агаар орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажил

Д.д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал төгрөг
1	Агаар бохирдуулсны төлбөр хураамж төлөх	Би Ти Девелопмент ХХК	Далд уурхайн орчинд өөрийн эзэмшил болох ковш-1 ажиллаж байгаа бөгөөд тус – техник дээр агаар бохирдлын төлбөрийг төлсөн.
	Шүүрлийн усыг хуримтлуулан уурхайн дотоод тээвэрлэлтийн зам, овоолгоос үүсэх тоосжилтыг дарж усалгаа хийж сайжруулан арчилан тордох		Замын арчилгаанд шүүрлийг усыг хаврын хуурайшил болон бусад улиралд тогтмол хэрэгжүүлсэн. Уурхайн орчимд машин техник багасгаж тоосжилтыг багасгах зорилгоор хурданы хязгаарлалтыг хийж өглөө болонгон жолооч нарт давтан зааварчилгаа өгч ажилласан.
	Нийт төлбөр		690 056 төгрөг

Гадаргын болон газрын доорх ус			
2	Ус ашиглах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл гаргуулж гэрээ байгуулах	Байгаль орчны мэргэжилтэн	2025 оны 02 дүгээр сарын 07 өдрийн Е-2501-000302 дугаар бүхий ус ашиглах дүгнэлтийг Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох усны газраар гаргуулсан. 2025 оны 03 сарын 11-ны өдрийн А/07 тоот ус ашиглах зөвшөөрөлийг мөн 2025 оны 03 сарын 11-ны өдрийн 03 дугаартай ус ашиглах гэрээг Умард говийн гүвээт – Халхын дундад талын сав газрын захиргаатай байгуулсан.
3	Усны гэрээ дүгнэсэн тайлан мэдээг төрийн захиргаанд хүргүүлэх		2025 оны усны тайланг 11-р дүгээр сарын 15 дотор Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Усны нөөц, ашиглалт, хамгаалалт хариуцсан газар, 12-р дугаар сарын 15-ний дотор Умард говийн гүвээт- халхын дундад талын сав газар болон Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг усны газарт тус тус хүргүүлэн ажиллаж байна.
4	Шүүрлийн уснаас шинжилгээ хийлгэх		Шүүрлийн уснаас улирал тутамд албан ёсны баталгаажсан газар буюу Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв болон уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төвөөр шинжилгээг 4, 7, 10, 11 саруудад тус тус хийлгэсэн.
5	Уст цэг болон булаг шандын эхийг цэвэрлэх	Байгаль орчны мэргэжилтэн	Шүүрлийн уснаас үүссэн Алтатын гол болон нуурын эргэн тойрны цэвэрлэгээг хагас жил тутамд хийж гүйцэтгэсэн.
6	Хаягдал усны дүгнэлт гаргуулж, орон нутагдаа гэрээ байгуулж, төлбөр төлөх		2025-04-08 өдрийн Е-2503-000080 дугаар бүхий Хаягдал усны дүгнэлтийг Умард говийн гүвээт- халхын дундад талын сав газраар хаягдал усны дүгнэлтийг гаргуулан Хаягдал усны төлбөр болох 406,125 төгрөгийг бүрэн төлж барагдуулсан.
	Нийт төлбөр		1 051 125 төгрөг
Хөрсөн бүрхэвч, газрын гадарга			
7	Тогтсон нэг маршрутаар явах, нэмж шинээх зам гаргахгүй байх	Байгаль орчны мэргэжилтэн	Уурхайн болон уурхайн гадна зөвхөн тогтоосон замаар явж нэмж шинэ зам гаргахгүй байх талаар өглөөний болон ХАБ-н сургалтан тогтмол зааварчилгаа өгч ажиллаж байгаа. Тэсэлгээний дотоод тээврийн маршрутыг баталж үйл ажиллагаад мөрдлөгө болгон ажиллаж байна.

8	Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, тусгай зориулалт бүхий цэгт цуглуулах	Байгаль орчны мэргэжилтэн	2025-04-03 өдөр Айраг сумын засаг даргатай хог хаягдлын гэрээр байгуулан ахуйн хэрэглээнээс гарсан хогийг ангилан ялган ялгаж Айраг сумын хогийн цэгт ачуулан нэгдсэн нэг цэг дээр байршуулсан. Мөн дахин ажиллах боломжтой усны савыг хаяахгүй Айраг сумын цэвэр усны газраас ус авхад ашиглаж хог хаягдлыг буруулах замаар ажиллаж байна.
9	Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд хог хаягдлыг цэвэрлэх		Уурхайн орчимд үүссэн хог хаягдлыг ангилан ялгаж зохих газар нь хүргүүлж ажиллаж байна. Төмрийн хог хаягдлыг нэг цэг дээр бөөгнүүлэн Айраг сумын төмөр авах цэг тушаах. Машин техникээс гарсан дугуй болон бусад хог хаягдлыг аюултай хог хаягдал авдаг аж ахуйн нэгжтэй гэрээ хийн ажиллаж байна.
10			
11			
Нийт төлбөр		2 950 000 төгрөг	
Амьтны аймаг			
12	Олборлолтын талбайд мал амьтан нэвтрэхээс сэргийлж, аюулгүй бүс татах	Байгаль орчны мэргэжилтэн	Уурхайн ойр орчимд хөдөлгөөн харьцангуй их мөн 2 замын дунд байрладаг тул зэрлэг амьтан нэн ховор.
	Нийт		500 000төгрөг

3.2. Нөхөн сэргээлтэд хийгдсэн ажил

Хүснэгт 6. Нөхөн сэргээлтэнд хийгдсэн ажлууд

Д.д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал төгрөг
1	Гар аргаар олборлолтонд өртсөн талбайг дүүргэх	Байгаль орчны мэргэжилтэн	Уурхайн ашиглалтын талбайд хүрээнд хуучин гар аргаар олборлолтонд өртсөн 2.08 га талбайд канавыг шорооны овоолгоос шороог зөөж дүүргэлт хийн техникийн сэргээлтийг ажлыг хийж гүйцэтгэсэн.
2	Тус онд өрөмдлөг, канав, далд малталтын хайгуулын ажил гүйцэтгэвэл зохих журмын дагуу нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэх		Хайгуулын явцад өрөмдсөн өрөмдлийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэв.
3	Биологийн нөхөн сэргээлт хийх талбайг бэлтгэх		Техникийн нөхөн сэргээлт хийсэн газрыг тэгшлэх ирэх онд биологийн нөхөн сэргээлт хийхийн тулд тус газарт малын бууцыг тарааж бэлтгэв.
	Нийт зардал		15 000 000 төгрөг

3.3. Хөрс, ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад хийгдсэн ажлууд

Хүснэгт 7. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлууд

Д.д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал төгрөг
1	Мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгэх, объёмыг тодорхой болгох	Байгаль орчны мэргэжилтэн	Уурхайн хэмжилтийг тусгай зөвшөөрөлтэй “Профешнл ланд сүрвэй” ХХК 30 хоног тутамд маркшейдерийн хэмжилтийг хийлгэж уурхайн олборлолтын үеийн хүдрийн болон шорооны эзлэхүүний мэдээг гаргаж холбогдох газруудад мэдээлдэг.
2	Техникийн нөхөн сэргээлт хийх		2025 онд хуучин гар аргаар олборлолтонд өртсөн 2.08 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн. Дүйцүүлэн хамгаалах талбайн хүрээнд сумаас зааж өгсөн талбайд хийж гүйцэтгэсэн.
3	Ашиглалтын талбайд мод тарих		Тэрбум модны хөтөлбөрийн дагуу 1тн баялаг нэг мод арга хэмжээний хүрээнд ашиглалтын талбайд ногоон байгуулалмж бий болгох зорилгоор 550 хайлс, улайс, бургас мод нутагшуулах зорилгоор нэмэж тус тус тарьсан.
	Нийт зардал		7 500 000 төгрөг

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд хийгдсэн техникийн нөхөн сэргээлт хийсэн
ажлын явцын зураг



Техникийн нөхөн сэргээлт хийсэн ажлын зураг



Хүснэгт 8. Түүх соёлын өдийг хамгаалах хүрээнд хамгаалахад хийгдсэн ажлууд

Д.д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал төгрөг
1	Археологийн дурсгалыг хөндөхгүй байх, ажилчид болон төслийн холбогдох хүмүүст мэдээлэл өгч танилцуулах	Уурхайн дарга	Археологийн судалгааны хүрээнд илсэрсэн булшыг шинээр ирсэн ажилчид болон жолооч нарт мэдэгдэж ажлыг эхлүүлдэг
2	Газар шорооны ажлын явцад соёлын биет өв илэрсэн тохиолдолд ажлаа зогсоож, холбогдох байгууллагад нэн даруй мэдэгдэх, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах		2025 оны олборлотын ажилд эртний ховор өв илрээгүй байна.
	Нийт		200 000 төгрөг

3.4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

2025 онд уурхайн талбайдаа хайлас, бургас, улайс нийт 550 моднуудыг тарьсан. Нийт зардал нь 2 500 000 төгрөг зарцуулсан.





Зураг 2. Мод тарьж буй байдал

3.5. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлсэн ажлууд

Хүснэгт 9. Хог хаягдлыг менежментээр хийгдсэн ажлууд

Д.д	Төлөвлөгөө	Хариуц сан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал /төгрөг/
1	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангах	ХАБ ажилтан	Ажилчдын аюулгүй ажиллуулахыг нэн тэргүүнд тавьж шаардлага хувцас хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжөөр цаг бүр ханган ажилласан.
2	Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг байршуулах, тэдгээрийн бэлэн байдлыг хангах		Осол эрсдэлээс урьдчилан сэргийлж галын аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллаж шаардлагатай тоног төхөөрөмжийг хангалтыг хийсэн.
3	Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг холбогдох газраар гаргуулах		Уурхайн кемп 2025 оны 01 сарын 24 өдрийн 0026046 дугаар болон тэсэлгээний агуулахын галын дүгнэлтийг 2025 оны 01 сарын 24 өдрийн 0001953 дугаар бүхий галын аюулгүй байдлын дүгнэлтүүдийг Дорноговь аймгийн Онцгой байдлын газраас гаргуулсан.
4	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг ханган нийлүүлэгчээс худалдан авч, аюулгүй байдлыг ханган тээвэрлэх		Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тусгай зөвшөөрөлтэй тээвэрлэлтийн компаниаар зохих журмын дагуу аюулгүй байдлыг хангуулан тээвэрлэлтийг хийдэг.

5	Агуулахаас тэсрэх материалыг ажлын талбай руу тогтоосон маршрутын дагуу тээвэрлэх		Агуулахаас тэсрэх материалыг зөвшөөрөлтэй тээврийн хэрэгслээр тогтоосон маршрутын дагуу хийж гүйцэтгэж байна.
6	Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн аюулгүй байдалд хяналт тавих, зориулалтын тусдаа агуулахад хадгалах		Тэсрэх материал хадгалах агуулахыг эрх бүхий байгууллагаар зураг төслийг баталгаажуулан зориулалтын агуулахад хадгалалтыг хийж байна.
7	Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн ашиглалт зарцуулалтын бүртгэл хөтөлж, холбогдох байгууллагад тайлагнах	Тэсэлгээний удирдагч	Тэсрэх материалын бүртгэлийг тэсэлгээний нярав хянаж орлого зарлагыг хийж сар бүрийн 1 нд сумын цагдаад тайлагнаж бүргүүлэн мөн улирал тутамд АҮ,ЭБЯам, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Дорноговь аймгийн, Цагдаагийн газарт, Онцгой байдлын албанд тус тус мэдээ тайлан хүргүүлэн ажиллаж байна.
8	ХАБЭА-н сургалт зохион байгуулах	ХАБ-ын ажилтан	ХАБЭА-н сургалтын жилд нэг удаа мэргэжлийн газраар сургалт авч ээлж солигдох бүрд ХАБ сургалт тогтмол хийж аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.
9	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах		Дотоод хяналт шалгалтыг комиссыг захиралыг тушаалаар баталж тогтмол ажлуулан хяналтыг тавьж ажиллаж байгаа.
Нийт зардал			Үйл ажиллагааны зардал





3.6. Түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс

Ордын ашиглалтын талбай түүний ойр орчимд түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс байхгүй болно.

3.7. Химийн бодис эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Тус төсөл нь химийн бодис ашиглаагүй.

3.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулсан. Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцан ажилласан.

Хүснэгт 10. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажил

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хариуцсан эзэн	Тайлбар, зарцуулсан зардал төгрөг
1	Орон нутагтай хог хаягдал ачиж зайлуулах гэрээ байгуулах, хог хаягдлыг тогтмол зайлуулж, үйлчилгээний хөлсийг тухай бүр төлөх	Байгаль орчны мэргэжилтэн	2025 оны хог хаягдлын төлбөр болох 1,200,000 төгрөгийг бүрэн төлж барагдуулсан.
2	Хаягдал ус зайлуулах дүгнэлтийг Умард говийн гүвээт- Халхын дундад талын сав газрын захиргаас гаргуулах		2025-04-08 өдрийн Е-2503- 000080 дугаар бүхий Хаягдал усны дүгнэлтийг Умард говийн гүвээт- халхын дундад талын сав газраар хаягдал усны дүгнэлтийг гаргуулсан.
	Нийт төлбөр		1 950 000 төгрөг

3.9. Хяналт шинжилгээний ажлын биелэлт

№	Хяналт шинжилгээний дээж	Хяналт шинжилгээний үзүүлэлт	Хяналт шинжилгээ явуулсан хугацаа	Хяналт шинжилгээ явуулсан байршил	Хяналт шинжилгээ хийсэн багаж, холбогдох стандарт
1	Ус	Усны ерөнхий химийн шинжилгээ, бактериологийн шинжилгээ Ажилчдын ундны ус нөөцлөх сав нийт 1 цэгт Шүүрлийн усанд нийт 1 цэгт	Тус бүр 1-4 удаа	Унд ахуйн ус	Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2008, Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005, Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага MNS 4288:1995,
2	Хөрс	Хөрсний агрохими, хүнд металлын бохирдол Төслийн талбайн мониторингийн цэгт нийт 2-3 цэгт Олборлолтын талбай болон хүдрийн овоолго нийт 1-2 цэгт	Хавар, намар 2 удаа	Уурхайн эвдэгдээгүй хөрс, эвдэгдсэн хөрс	- MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл - MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох - MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам - MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх
3	Агаар	Азотын давхар исэл (NO₂) Нийт тоосонцор	Хавар намар 2 удаа	Ангилан ялгах хэсгийн орчинд нийт 1 цэгт	- Дорноговь аймгийн УЦУОША-ны харьяа БОШЛ-той хамтран ажилласан. Агаарын шинжилгээг нийт 3 цэг дээр хийж хяналтын нэг цэг бас хийсэн. - MNS 4585:2016

2025 оны Орчны Хяналт Шинжилгээний ажлыг тус оны хавар 4-р сард, намар 7, 10 сар, 11 сард тус тус хийж гүйцэтгэсэн. Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу ус, хөрс, агаарын шинжилгээ хийсэн.

Хүснэгт 11. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Д.д	Зардлын утга	Нийт зардал төгрөг
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	690 065
2	Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	2 250 000
3	Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	500 000
4	Хог хаягдлын менежментээр хийгдсэн ажлын зардал	1 950 000
5	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	
6	Нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах ажлын зардал	22 500 000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	3 640 000
8	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	2 000 000
	2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	33 530 065

ДҮГНЭЛТ

Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт орших MV-008469 тоот “Өмнөд Хар-Айрагийн хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах” уурхай нь Айраг сумын нутаг дэвсгэр L-49-75 хавтгай дээр, Хайртын уурхайн зүүн талд, Улаанбаатар хотоос зүүн урагш, төмөр замаас 310 км зайд, Айраг төмөр замын өртөөнөөс 8.5 км зайд оршино.

Өмнөд Хар-айраг хайлуур жоншны ордын талбай нь 76.08 гектар талбайг хамардаг.

Уурхай 2021 оны уулын ажлын төлөвлөгөөний дагуу 03-р сараас бэлтгэл ажил хийгдсэн.

2025 онд нөхөн сэргээлтийн ажил уурхайн ашиглалтын талбайд болон дүйцүүлэх хамгаалах талбайн хүрээнд сумаас зааж өгсөн талбайд тус тус техникийн нөхөн сэргээлт хийгдсэн.

2025 оны Орчны Хяналт Шинжилгээний ажлыг тус оны 4-р сард болон 7,10,11 сард тус тус хийж гүйцэтгэсэн.

Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу ус, хөрс, агаарын шинжилгээ хийсэн.

Нийт 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, нөхөн сэргээлтэд нийт 33 530 065 **мян.төгрөг** зарцуулсан байна.